



# Хүнсний гол нэрийн барааны үнэ


2019 оны 4-р сарын 17-ны байдлаар

2019 оны 4-р сарын 17-ны байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 4.6 хувиар өсөж, өмнөх 7 хоногтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

**Махны дундаж үнэ:** 2019 оны 4-р сарын 17-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 10.2 хувь, үхрийн ястай махны үнэ 2.8 хувь, үхрийн цул махны үнэ 3.5 хувь, ямааны ястай махны үнэ 6.3 хувиар өссөн бол, адууны ястай махны үнэ 0.7 хувиар буурсан байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 0.1 хувиар өссөн бол, үхрийн цул махны үнэ 1.3 хувь, адууны ястай махны үнэ 0.7 хувиар буурч, бусад махны үнэ өөрчлөлтгүй байна.

**Зураг 1.** Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ, төгрөг




2019 оны 4-р сарын 17-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 8744 төгрөг, үхрийн /ястай/ мах 9642 төгрөг, үхрийн цул мах 11687 төгрөг, адууны /ястай/ мах 6697 төгрөг, ямааны /ястай/ мах 6399 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).

**Гурилын үнэ:** 2019 оны 4-р сарын 17-ны байдлаар гурилын үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос 1-р зэргийн гурилын үнэ 0.1 хувиар өссөн бол бусад төрлийн гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

**Будаа, элсэн чихрийн дундаж үнэ:** 2019 оны 4-р сарын 17-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна. Элсэн чихрийн үнэ өмнөх сараас 3.4 хувиар өссөн бол өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна. (Зураг2).

**Зураг 2.** Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ, төгрөг



**Төмс, хүнсний ногооны дундаж үнэ:** 2019 оны 4-р сарын 17-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 22.7 хувь, луувангийн үнэ 25.1 хувь, байцааны үнэ 23.3 хувь, хүрэн манжингийн үнэ 8.5 хувь, бөөрөнхий сонгины үнэ 6.1 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногоос төмсний үнэ 0.9 хувь, луувангийн үнэ 1.9 хувь, байцааны үнэ 4.1 хувиар өссөн бол, хүрэн манжингийн үнэ, бөөрөнхий сонгины үнэ өөрчлөлтгүй байна.

**Зураг 3. Өндөг, сүүний дундаж үнэ, төгрөг**

	Үнэ	Өмнөх сараас	Өмнөх 7 хоногоос
	1 864 ₮	-3.0% ↓	-1.7% ↓
	2 659 ₮	-2.7% ↓	0.0%
	329 ₮	0.0%	0.0%

**Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ:** 2019 оны 4-р сарын 17-ны байдлаар өмнөх сараас элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 0.7 хувь, задгай сүүний үнэ 3.0 хувь, савласан /1 литрийн/ сүүний үнэ 2.7 хувиар буурсан байна. Өмнөх 7 хоногоос задгай сүүний үнэ 1.7 хувиар буурч, савласан /1 литрийн/ сүүний үнэ болон элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Цөцгийн тосны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна. Ургамлын тосны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байлаа. Өндөгний үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна.

**ҮСХ-ны Эдийн засгийн статистикийн газар  
2019 оны 4-р сарын 17**